

ТАНДАЛТ СУДАЛГАА, БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН
2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

№	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин		Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /Хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь	ХШГ-ний хувь
					Эхний хагас жил	Сүүлийн хагас жил			
	Гүйцэтгэлийн зорилт 1.1.1 Хууль тогтоомж, бодлого, шийдвэр, журам, стандартыг боловсруулах, шинэчлэх, санал хүргүүлэх ажлыг зохион байгуулах, боловсронгуй болгох чиглэлээр судалгаа, шинжилгээ хийх	Улсын төсөв	Шинэчлэх болон өөрчлөлт оруулах санал боловсруулсан баримт бичгийн тоо	-	1	-	Тандалт судалгаа хийгдэж байгаа бөгөөд үр дүн эцэслэгдээгүй тул боловсруулсан санал боловсруулагдаагүй байна.	100%	
1.1.1.1	Хяналт шалгалтын тайлан, иргэдийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд хийсэн дүн шинжилгээнд үндэслэн бодлогын судалгаа хийж, хууль тогтоомж, бодлого, шийдвэр, журам, стандартыг боловсруулах, шинэчлэх чиглэлээр холбогдох байгууллагад санал хүргүүлэх	Улсын төсөв	Хийж дууссан судалгааны тайлан (тоо)	-	1		"Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эмнэлгийн цаг товлох, эмнэлгийн тусламж үйлчилгээ авахад тулгарч байгаа бэрхшээл, шийдвэрлэх арга зам" бодлогын тандалт судалгааг хийх удирдамжийг ЗГХХГ-ын даргын 2026 оны 3 дугаар сарын 06-ны өдрийн А/19 дүгээр тушаалаар батлуулан гүйцэтгэж байна. Судалгаанд шаардлагатай мэдээллийг ЭМЯ, ЭМДЕГ, ХГБХХЕГ, "И-монгол академи" УТҮГ зэрэг нийт 42 байгууллагаас гаргуулаж авсан. Иргэнд эмнэлгийн үзлэгийн цаг олгох асуудлыг зохицуулсан хууль тогтоомж, тогтоол шийдвэр, мэдээлэлд бодлогын дүн шинжилгээ хийсэн. Судалгаанд үндэслэн хууль тогтоомж, бодлого, шийдвэр, журам, стандартыг боловсруулах, шинэчлэх чиглэлээр холбогдох байгууллагад санал хүргүүлэхээр тайланг бэлтгэж байна.	70%	70%

							Бодлогын тандалт судалгаа хийх аргачлалын төслийг боловсруулан ЗГХХГ-ын даргын 2026 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн А/33 дугаар тушаалаар батлуулсан. Аргачлалыг "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эмнэлгийн цаг товлох, эмнэлгийн тусламж үйлчилгээ авахад тулгарч байгаа бэрхшээл, шийдвэрлэх арга зам" бодлогын тандалт судалгаанд ашиглаж байна.		
Гүйцэтгэлийн зорилт 2.1.1 Засгийн газрын хяналт шалгалтын үйл ажиллагааг хууль, журамд нийцүүлэн хийж, үр дүнг тайлагнах		Улсын төсөв	Нийт арга хэмжээний хэрэгжилтийн дундаж (Хувь)	-	100		Арга хэмжээний хэрэгжилт 100%	100%	
2.1.1.1	Хяналт, шалгалтын үр дүнд үндэслэн хууль тогтоомж, бодлого шийдвэр, дүрэм, журам, стандартыг шинэчлэх, нэмэлт өөрчлөлт оруулах талаар холбогдох байгууллага, албан тушаалтанд санал, зөвлөмж хүргүүлэх	Улсын төсөв	Дүн шинжилгээний тайлан (тоо)	-	-	1	Тайлагнах хугацаа болоогүй.	ХБ	ХБ
2.1.1.2	Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын чиг үүрэгт хамаарах асуудлаар хүн, хуулийн этгээдээс гаргасан өргөдөл, гомдолд мэдээлэл технологийн чиглэлээр тандалт судалгаа, шинжилгээ хийх нөхцөлийг бүрдүүлэх	Улсын төсөв	Гүйцэтгэлийн хувь	100	100	-	Төрийн захиргааны төв байгууллага, агентлаг, нутгийн захиргааны байгууллага, төрийн өмчит болон хуулийн этгээдийн өргөдөл гомдол хариуцсан 69 албан хаагчаас Өргөдөл, гомдлын нэгдсэн сангийн ашиглалттай холбоотой судалгааг 2026 оны 04 дүгээр сарын 13-23-ны өдрийн хооронд хийсэн. Уг судалгаа нь өргөдөл, гомдлын нэгдсэн мэдээллийн сангийн ашиглалт, түүний хэрэглээтэй холбоотой мэдээлэл технологийг хөгжүүлэх чиглэлээр хийгдсэн. Судалгаагаар тухайн байгууллагын ашигладаг ERP систем нь өргөдөл, гомдлын нэгдсэн мэдээллийн санд холбогдсож, өргөдөл, гомдлыг нэгдсэн	100%	100%

							мэдээллийн сан руу илгээж байгаа эсэх болон өргөдөл, гомдлыг бүртгэх, шилжүүлэх, шийдвэрлэх, тайлагнахад тулгарч байгаа асуудлуудыг тогтоосон болно. Судалгааны үр дүнг иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан 2026 оны I улирлын өргөдөл, гомдлын тайланд тусган 2026 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 01/658 дугаартай албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.		
Гүйцэтгэлийн зорилт 2.2.2 Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн бодит үр дүнг нэмэгдүүлэх		Улсын төсөв	Нийт арга хэмжээний хэрэгжилтийн дундаж хувь	-	100		Арга хэмжээний хэрэгжилт 100%		
2.2.2.1	Төрийн байгууллагын өргөдөл, гомдол хариуцсан албан хаагчдад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, мэргэшүүлэх сургалт зохион байгуулах	Улсын төсөв	Зохион байгуулах сургалт (тоо)	4	1	1	Монгол Улсын Ерөнхий сайд, Шадар сайдын харьяа 4 агентлаг, төрийн өмчит 63, орон нутгийн өмчит 132 хуулийн этгээд, төрийн болон нутгийн захиргааны бусад байгууллагын нийт 830 албан хаагчид "Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаарх тайлан гаргах, хүргүүлэх журам, тайлангийн маягтын тухай" сургалтыг 2026 оны 02 дугаар сарын 26, 27-ны өдөр цахимаар зохион байгуулсан. Мөн Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын нийт албан хаагчдад зориулсан "Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаарх тайлан мэдээ гаргах, хүргүүлэх тухай журам"-ын зохицуулалттай холбоотой цахим сургалтыг 2026 оны 05 дугаар сарын 06-нд зохион байгуулсан.	100%	100%
2.2.2.2	"Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээг нэгтгэн, үр дүнг Засгийн газрын хуралдаанд танилцуулах	Улсын төсөв	Танилцуулсан тайлан (тоо)	4	1	1	Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль (1995), Засгийн газар дахь хяналтын тухай хууль (2022), "Иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2005 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн 67	100%	100%

							дугаар тогтоол, Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 онд баталсан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаарх тайлан, мэдээлэл гаргах, хүргүүлэх журмын хүрээнд төрийн байгууллага, албан тушаалтан болон Засгийн газрын Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвд хандаж гаргасан өргөдөл, гомдлын тайлан мэдээг нэгтгэн дүн шинжилгээ хийсэн. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлын 2025 оны жилийн эцсийн тайланг Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн хуралдаанд танилцуулсан.		
2.2.2.3	Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдалд иргэдийн сэтгэл ханамжийг үнэлэх ажлыг зохион байгуулах	Улсын төсөв	Үнэлгээний тайлан (тоо)	-	1	-	2025 оны өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан мэдээнд үндэслэн Боловсролын яам, Эрчим хүчний яам, Мал эмнэлгийн ерөнхий газар, Төв аймаг, Дорнод аймгийн төрийн байгууллагад өргөдөл, гомдол гаргасан 703 иргэнийг хамруулан сэтгэл ханамжийн судалгаа хийсэн. Судалгаагаар өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн өнөөгийн байдал, шийдвэрлэлтийг эргэн мэдээлсэн эсэх, тухайн гомдлын шийдвэрлэсэн байдалд хэр сэтгэл ханамжтай байгааг үнэлж, тайланг боловсруулсан. Уг судалгааны үр дүнг 2025 оны жилийн эцсийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдлын тайланд тусгасан болно.	100%	100%
Гүйцэтгэлийн зорилт 3.1.1 Төрийн байгууллагуудад процессын дахин инженерчлэл хэрэгжүүлэх, зөвлөн чиглүүлэх замаар төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, бүтээмжийг сайжруулах		Улсын төсөв	Нийт арга хэмжээний хэрэгжилтийн дундаж (хувь)	-	100	-	Арга хэмжээний хэрэгжилтийн дундаж	84.2%	
3.1.1.1	Засгийн газрын харьяа төрийн болон нутгийн захиргааны	Улсын төсөв	Хийж дууссан судалгааны тайлан (тоо)	-	1	-	ЗГХЭГ-ын даргын 2025 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн 123 дугаар тушаалаар баталсан Ажлын хэсэг ЗГХЭГ,	100%	

	байгууллагын нийтлэг чиг үүргийн шинжилгээ хийж, санал дүгнэлтийг Засгийн газарт танилцуулах						ЗГХХГ, 16 яам, төрийн цэргийн байгууллагаас бусад 36 агентлаг болон орон нутаг дахь харьяа 418 газар, 21 аймгийн Засаг даргын Тамгын газар болон Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 126 агентлаг, нийслэлийн ЗДТГ болон Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 18 агентлаг, нийт 638 байгууллагын нийтлэг чиг үүрэгт дүн шинжилгээ хийсэн. Судалгаагаар орон тооны хязгаарыг өөрчлөх, нийтлэг чиг үүгийн албан хаагчийн тоог нийт орон тооны 20 хувихс хэтрүүлэхгүй байх, төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллагын нийтлэг чиг үүрэг хариуцсан албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг нэгдсэн агуулгаар боловсруулах, холбогдох тогтол, шийдвэрийг шинэчлэх, хуульд заасан чиг үүрэг, бүрэн эрхийн нийцлийг хангах шаардлагатай болохыг тодорхойлсон. Судалгааны үр дүнг нэгтгэн санал, дүгнэлт, зөвлөмж бүхий нэгдсэн тайланг Засгийн газрын 2026 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн хуралдаанд танилцуулсан.		100%
3.1.1.2	Улсын хэмжээнд төрийн албан хаагчийн сэтгэл ханамжийн нөхцөл байдлын шинжилгээг хамтран хэрэгжүүлэх	Улсын төсөв	Хийж дууссан судалгааны тайлан (тоо)	1	1	1	Төрийн албан хаагчийн сэтгэл ханамжийн судалгаа хийх удирдамжийг Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын даргын 2026 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн А/12 дугаар тушаалаар батлуулсан. Удирдамжийн дагуу судалгаанд төрийн захиргааны төв 18, төрийн захиргааны 40, нутгийн захиргааны 22 буюу нийт 80 байгууллагын 12061 албан хаагч хамруулан гүйцэтгэсэн. Судалгаанд хамрагдсан байгууллагуудын төрийн албан хаагчдын сэтгэл ханамжийн түвшин 68.3 хувь буюу "Дундаж" гэж үнэлсэн. Үүнээс төрийн захиргааны төв байгууллагын хувьд 66.7, төрийн захиргааны байгууллагад 67.4, нутгийн захиргааны байгууллагад 70.9 хувьтай	100%	100%

							байлаа. Судалгааны нэгдсэн тайланг 2026 оны 03 дугаар сарын 24-ний өдөр Үнэлгээ, мониторингийн газарт хүлээлгэн өгсөн.		
3.1.1.3	Удирдлагын академитай хамтран төрийн байгууллагад процессын дахин инженерчлэл хийх сургалтын модулийг боловсруулах	Улсын төсөв	Сургалтын хөтөлбөр, модуль	0	1	-	Төрийн байгууллагад процессын дахин инженерчлэл хийх сургалтын хөтөлбөр/модуль боловсруулах ажлын хүрээнд Удирдлагын академитай 3 удаагийн уулзалт зохион байгуулж, сургалтын агуулга, чиглэлийг тодорхойлсон. Сургалтын хөтөлбөрт "Процессын дахин инженерчлэлийн ерөнхий ойлголт олгох", "Процессын шинжээч буюу сургагч багш бэлтгэх" гэсэн 2 үндсэн чиглэлээр сургалтын хөтөлбөрийн төслийг бэлтгэсэн. Талууд сургалтын агуулга, зохион байгуулалт, хэрэгжилтийг хангах хүрээнд хамтарсан Ажлын хэсэг байгуулахаар тохиролцсоны дагуу тушаалын төслийг боловсруулан батлуулахаар ажиллаж байна. Тухайн арга хэмжээг улсын төсөвт суулгах санал өгсөн боловч батлаагүйн улмаас санхүүжилтийн эх үүсвэр олох шаардлага үүсч бусад байгууллагатай хэлэлцэл хийж худалдан авах ажиллагааны ажлын даалгавар болон бусад материалын боловсруулж өгсөн. Хэрэгжилтийг тайлагнах хугацаа болоогүй.	ХБ	ХБ
3.1.1.4	Сургалтын модулийн хүрээнд төрийн албаны сургалтын байгууллага болон төрийн байгууллагад сургалт хийх	Улсын төсөв	Сургалтын дараах үнэлгээ (хувь)	-	60	-	Төрийн байгууллагад процессын дахин инженерчлэл хийх сургалт зохион байгуулахад шаардлагатай төсвийг Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас гаргуулахаар харилцан тохиролцсон. Үүнийг дагуу уг ажлыг гүйцэтгэх Ажлын даалгаврыг боловсруулж, ЦХХХЯ-нд хүргүүлж, гүйцэтгэгчийг шалгаруулах тендерийг 2026 оны 04 дүгээр сард зарласан боловч тендер шалгаруулалт амжилтгүй болсон. Одоогоор тухайн арга хэмжээнд шаардагдах төсвийг байгууллагаас	ХБ	ХБ

							гаргуулахаар төлөвлөж, тендерийн баримт бичиг, ажлын даалгаварын төслийг боловсруулж, Тамгын газарт хүргүүлээд байна. Хэрэгжилтийг тайлагнах хугацаа болоогүй		
3.1.1.5	Төрийн үйлчилгээтэй холбоотой иргэдээс ирүүлсэн хамгийн их өргөдөл, гомдол, саналд үндэслэн процессын дахин инженерчлэл, процессын дахин загварчлалын ажлыг хийж гүйцэтгэнэ.	Улсын төсөв	Процессын дахин инженерчлэл хийсэн байгууллага (тоо)	1	1	-	Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтэд 2024, 2025 онд хийсэн судалгааны дүн болон аймаг, нийслэлийн ЗДТГ-ын үйл ажиллагааны 2024 оны ерөнхий үнэлгээ зэргийг харгалзан ЗГХХГ-ын даргын 2026 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн А/10 дугаар тушаалаар баталсан удирдамжийн дагуу Хөвсгөл, Сүхбаатар аймгийн ЗДТГ, ХААГ, СХДАГ, ГХБХБГ, ОНӨГ, ЭМГ, БОГ болон Архивын хэлтэс Процессын дахин инженерчлэл хийхээр шийдвэрлэсэн. ПДИ-ийн судалгаа шинжилгээ хийхэд шаардлагатай байгууллагын хүний нөөц, санхүү, бусад үйл ажиллагааны мэдээллийг 2026 оны 03-р сарын 20-ны өдөр хүлээн авч дүн шинжилгээ хийсэн. ЗГХХГ-ын даргын 2026 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн А/63 дугаар тушаалаар Хөвсгөл, Сүхбаатар аймагт ПДИ хийх Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг баталж, 2026 оны 06-р сарын 08-12-ны өдөр Хөвсгөл аймагт газар дээрх судалгааны ажлыг гүйцэтгэв. ПДИ-ийн судалгааны тайланг тушаалд заасан хугацаанд танилцуулахаар ажиллаж байна.	90%	90%
		Улсын төсөв	Дахин загварчилсан төрийн үйлчилгээний процесс (тоо)	-	10	10	Төрийн үйлчилгээтэй холбоотой иргэдээс Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төв-д 2023–2025 онд гаргасан өргөдөл, гомдол, саналд үндэслэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хамаарах 9 үйлчилгээ, мөн аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон түүний харьяа агентлагуудтай холбоотой 12 үйлчилгээг тус тус тодорхойлж, нийт 21		

							<p>процессыг дахин загварчлах бэлтгэл ажлыг төлөвлөгөөг боловсруулж, гүйцэтгэхэд багуудад хувиарлагдан ажиллаж байна.</p> <p>Түүнчлэн удирдлагаас өгсөн үүргийн дагуу 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдөр аж ахуйн нэгжид хүндрэл, тодорхойгүй байдал үүсгэж буй үйлчилгээний процессын хүрээнд Улсын бүртгэлийн ерөнхий газраас үзүүлдэг үл хөдлөх хөрөнгийн барьцааны гэрээг бүртгэхтэй холбоотой судалгаа хийж, дахин загварчлах саналыг ЗГХЭГ-т танилцуулж дэмжүүлсэн.</p> <p>Дахин загварчлах үйлчилгээний жагсаалтад орсон үйлчилгээний процесст шинжилгээ хийх ажлыг Хөвсгөл аймагт гүйцэтгэв.</p>		
3.1.1.7	<p>Төрийн бодлого, үйлчилгээ, процессын шинжилгээ, шинэчлэлийг нотолгоонд суурилсан хэрэгжүүлэх зорилгоор 16 яамны үйл ажиллагаа, үзүүлж байгаа төрийн үйлчилгээ, процесс, хэрэглэгч, албан хаагчийн сэтгэл ханамжийн талаарх мэдээлэл цуглуулах, баяжилт хийх</p>	Улсын төсөв	<p>Нэгдсэн судалгааны санд бүртгэгдсэн төрийн үйлчилгээ, процесс (тоо)</p>	-	-	-	<p>Яамдын нийтлэг чиг үүргийн шинжилгээний мэдээлэл, иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлын 2023-2025 оны мэдээлэл, процессын дахин инженерчлэлийн хүрээнд цуглуулсан мэдээлэл, хууль тогтоомж, стандарт, үндэсний хөтөлбөрүүд, бүтэц, орон тоо, харьяа, нэгж, байгууллагын мэдээлэл, 2020-2026 оны хичээлийн жилийн статистик дүн мэдээ, салбарын хяналтын хуудас, хяналт шинжилгээ, үнэлгээний мэдээллүүдийг татан авч Microsoft teams-д сан бүрдүүлээд байна. Мөн яамдаас үзүүлж буй үйл ажиллагаа, төрийн үйлчилгээ, процесс, хэрэглэгч болон албан хаагчийн сэтгэл ханамжийн талаарх мэдээлэл цуглуулах ажлыг хийж байна.</p>	ХБ	ХБ
3.1.1.8	<p>Процессын дахин инженерчлэл хийгдсэн байгууллагуудын зөвлөмжийн хэрэгжилтэд процессын хяналтыг хийнэ.</p>	Улсын төсөв	<p>Зөвлөмжийн хэрэгжилт (хувь)</p>	-	30		<p>Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас 2023-2025 онд Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яам түүний харьяа 2 байгууллага, Эрүүл мэндийн яам түүний харьяа 2 байгууллага, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийг яам түүний</p>		

	(Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийг яам, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Эрүүл мэндийн яам)						харьяа нэг байгууллагад хэрэгжүүлсэн Процессын дахин инженерчлэлийн судалгаа, шинжилгээний ажлын хэрэгжилтэд процессын хяналт хийх ажлыг ЗГХХГ-ын даргын баталсан удирдамжийн дагуу гүйцэтгэлээ. ПДИ-ийн санал, зөвлөмжийн хэрэгжилтийг ЗГХХГ-ын даргын 2026 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 01/309, 01/310, 01/311 дугаартай албан бичиг хүргүүлж, процессын тайланд тусгагдсан санал, зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлан, мэдээлэл, холбогдох материалыг татан авч холбогдох баримтад судалгаа хийж, санал зөвлөмжийн хэрэгжилтийг 2026 оны эхний хагас жилийн байдлаар гаргаж, нэгдсэн тайланг гаргав. Хяналтаар ГБХНХЯ, түүний харьяа байгууллагад ПДИ-ийн тайлангаар өгсөн санал зөвлөмжийн 25 буюу 22% хэрэгжсэн, 77 буюу 68% нь хэрэгжилтийн шатанд, ЭМЯ, харьяа газарт хүргүүлсэн санал, зөвлөмж урьдчилсан дүнгээр 46.4% хэрэгжсэн, БОУАӨЯ, Ойн газарт өгсөн санал, зөвлөмжийн 58.4% хэрэгжилтийн шатанд байна. Түүнчлэн ГБХНХ-ийн салбарын ПДИ үр дүнг Сайд Т.Аубакирт 2026 оны 06 дугаар сарын 03-ны өдөр танилцуулсан.	90%	90%
3.1.1.9	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Төрийн үйлчилгээний шагнал (United Nations Public Service Awards (UNPSA)) 2027 онд шалгаруулалтад оролцох өргөдлийн материалын бэлтгэл ажлыг хангах	Улсын төсөв	Бэлтгэгдсэн өргөдлийн маягт (хувь)	50	20	30	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Төрийн үйлчилгээний шагналын тухай мэдээлэл боловсруулж, бэлтгэл ажлыг хангах төлөвлөгөө боловсруулсан. Шагналын ангилал, тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлт, өмнөх онуудад шагнал авч байсан Азийн хөгжиж буй орнуудын санаачилгын талаар болон Монгол Улсын Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв болон "И-Монголиа" нэгдсэн системээр бүртгүүлж байсан туршлагаас судалж мэдээлэл боловсруулсан. 2025 оны өргөдлийн маягт 50 асуултыг англи	70%	70%

							хэлнээс монгол хэлнээ орчуулсан. Өргөдлийн маягтын дагуу процессын дахин инженерчлэл хийсэн туршлага, эргэн хяналтын үр дүнгээс холбогдох мэдээллийг цуглуулж, анхан шатны боловсруулалт хийсэн		
	Гүйцэтгэлийн зорилт 3.2.1 Төрийн байгууллагад эрсдэлийн удирдлагын тогтолцоо нэвтрүүлэх	Улсын төсөв	Нийт арга хэмжээний хэрэгжилтийн дундаж (хувь)	-	100	-	Арга хэмжээний хэрэгжилтийн дундаж	86.7%	
3.2.1.1	Төрийн захиргааны байгууллагуудын эрсдэлийн удирдлагын төлөвшлийн түвшнийг тодорхойлж, санал, зөвлөмж боловсруулах, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулах	Улсын төсөв	Үнэлгээ хийж, зөвлөмж хүргүүлсэн байгууллага (тоо)	21	34	20	Төрийн байгууллагын эрсдэлийн удирдлагын бодлогын баримт бичгийн хэрэгжилт буюу төлөвшлийн түвшнийг тодорхойлох хүрээнд 16 яам, 36 агентлаг, 22 аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар буюу нийт төрийн захиргааны 74 байгууллагын 2025 оны хэрэгжилт, 2026 оны төлөвлөлт болон төлөвшлийн үнэлгээнд дүн шинжилгээ хийв. Дүн шинжилгээг байгууллагуудын өөрийн үнэлгээ болон хөндлөнгийн буюу шинжээчийн үнэлгээ гэсэн 2 түвшинд гүйцэтгэсэн. Үүнд: 1/ Эрсдэлийн удирдлагын төлөвшлийн өөрийн үнэлгээгээр, яамд, агентлаг, Засаг даргын Тамгын газрын дундаж үнэлгээ 2.5 буюу эрсдэлийн удирдлагын төлөвшил 2 дугаар түвшинд "Хөгжлийн эхний шатанд" гэж үнэлсэн. 2/ Эрсдэлийн удирдлагын 2025 оны хэрэгжилтийн тайлагналт, 2026 оны төлөвлөлтийг шинжилж, эрсдэлийн удирдлагын төлөвшлийн түвшнийг хөндлөнгөөс үнэлэхэд: - Түвшин 1 (Үндэс суурь байхгүй): Яамд болон агентлагуудын тус тус 50.0 хувь, ЗДТГ-уудын 63.6 хувь нь төлөвшлийн доод шатанд байна. - Түвшин 2 (Хөгжлийн эхний шатанд): Яамдын 37.5 хувь, агентлагуудын 30.5 хувь, ЗДТГ-уудын 36.4 хувь буюу нийт байгууллагуудын 34 хувь нь эрсдэлийн удирдлагыг	100%	100%

							<p>нэвтрүүлэх эхний алхмуудыг хэрэгжүүлж эхэлжээ.</p> <p>Нийт дүнгээр төрийн захиргааны 74 байгууллагын 54 хувьд нь эрсдэлийн удирдлагын суурь тогтолцоо хараахан бүрдээгүй бол 34 хувь нь хөгжлийн эхний шатанд буюу эрсдэлийн удирдлагын тогтолцоог бүрдүүлэх эхний алхмууд хийгдсэн байна.</p> <p>Дээрх үнэлгээ, судалгаанд тулгуурлан эрсдэлийн удирдлагын тогтолцоог бүрдүүлэх, үе шаттай сайжруулах зөвлөмж, чиглэлийг дээрх байгууллага тус бүрээр боловсруулан хэрэгжилтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор эргэн тайлагнах чиглэлийг хүргүүлэв.</p>		
3.2.1.2	Сонгогдсон төрийн захиргааны байгууллагад эрсдэлийн шинжилгээ хийж, санал зөвлөмж хүргүүлэх	Улсын төсөв	Зөвлөмжийн хэрэгжилт (хувь)	-	50	20	<p>ЗГХХГ-ын дарга бөгөөд Ерөнхий хянан шалгагчийн 2026 оны А/63 дугаар тушаалын дагуу 2026 оны 06 дугаар сарын 08-ны өдрөөс Хөвсгөл, Сүхбаатар аймгийн төрийн захиргааны зарим байгууллагад эрсдэлийн шинжилгээ хийж, санал, зөвлөмж хүргүүлэх ажлын удирдамж батлагдсан. Энэ хүрээнд Хөвсгөл аймагт ажиллаж, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга бөгөөд Ерөнхий хянан шалгагч П.Батбаатар болон удирдлагын бүрэлдэхүүн 2026 оны 6 дугаар сарын 12-ны өдөр Хөвсгөл аймагт ажиллаж, Хөвсгөл, Орхон, Булган аймгийн удирдлагууд, холбогдох албан хаагчидтай уулзалт хийв.</p> <p>Уулзалтын үеэр тус аймгуудад Засгийн газрын хяналтын холбогдох судалгаа, шинжилгээ, үнэлгээ, хяналт шалгалтын ажлын үр дүнг танилцууллаа. Тухайлбал, иргэдээс гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдал, нутгийн захиргааны байгууллагуудын бүтэц-чиг үүргийн болон мандатын шинжилгээ, төрийн албан хаагч болон хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаа,</p>	70%	50%

							байгууллагын эрсдэлийн удирдлагын төлөвшлийн үнэлгээний дүн, хөгжлийн бодлогын хяналт шинжилгээ, үнэлгээний дүнг аймаг тус бүрээр нарийвчлан авч хэлэлцсэн. Мөн судалгаа, үнэлгээ, шинжилгээний үр дүнд үндэслэн гурван аймагт тус бүрд зөвлөмж хүргүүлсэн бөгөөд биелэлтийг эргэн тайлагнахыг үүрэг болголоо. Энэ ажлын хүрээнд эрсдэлийн бүртгэлийг эцэслэж, тайланг бэлтгээд байна. Сүхбаатар аймагт ажиллах ажлын удирдамжийн хүрээнд ажлын хэсэг ажиллаж байна.		
3.2.1.3	Эрсдэлийн удирдлагын чиглэлээр гадаад, дотоодын судалгаа, шинжилгээ, сургалтын байгууллагуудтай хамтран ажиллах.	Улсын төсөв	Хамтран ажилласан арга хэмжээ (тоо)	-	1	-	2026 онд төрийн байгууллагын албан хаагчдыг чадавхжуулах, сургагч багш бэлтгэх ажлыг Санхүү, эдийн засгийн дээд сургуулиар гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулан ажиллаж байна. Гэрээний дагуу сургалтыг 2026 оны 06 дугаар сарын 22-ны өдрөөс 06 дугаар сарын 29-ний өдрийг хүртэлх хугацаанд үе шаттай зохион байгуулна. Мөн тус сургуулийн судалгааны байгууллагатай хамтран ажиллаж, эрсдэлийн удирдлагын гарын авлагыг хэвлүүлэн олон нийтэд түгээгээд байна. Олон улсын байгууллагатай хамтран ажиллах хүрээнд Азийн бүтээмжийн байгууллагын "Алсын хараа-2030" болон Стратегийн түншлэлийн хөтөлбөр (2026-2028)-ийн хүрээнд эрсдэлийн удирдлагын тогтолцоог бүрдүүлэх, албан хаагчдыг чадавхжуулах төслийн саналыг "Үндэсний Бүтээмжийн Мастер Төлөвлөгөө"-ний стратегийн тэргүүлэх чиглэлд тусгахаар хүргүүлсэн. Мөн "Төрийн бүтээмж ба хяналтын тогтолцооны шинэчлэл: Олон улсын түншлэл, хамтын ажиллагаа" сэдэвт уулзалт, хэлэлцүүлгийг 2026 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр НҮБ-тай хамтран зохион байгууллаа. Энэхүү	80%	90%

							уулзалт, хэлэлцүүлэг нь төрийн байгууллагын үйл ажиллагааны уялдаа холбоог бэхжүүлэх, бодлогын хэрэгжилтийн чанар, үр нөлөөг дээшлүүлэх, байгууллагын үйл ажиллагааг сурталчлах улмаар цаашдын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд чиглэсэн болно.		
	Гүйцэтгэлийн зорилт 3.2.2 Эрсдэлийн удирдлагын тогтолцоог нэвтрүүлсэн төрийн байгууллагуудын сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх	Улсын төсөв	Нийт арга хэмжээний хэрэгжилтийн дундаж (хувь)	-	100		Арга хэмжээний хэрэгжилтийн дундаж	80%	
3.2.2.1	Төрийн захиргааны төв байгууллага, Засгийн газрын агентлагуудын албан хаагчдын төлөөллийг оролцуулсан туршлага судлах арга хэмжээг зохион байгуулах	Улсын төсөв	Хамтран ажилласан арга хэмжээ (тоо)	-	1	-	1.Төрийн байгууллагын эрсдэлийн удирдлагын тогтолцоог бэхжүүлэх хүрээнд төрийн албан хаагчийн эрсдэлийн удирдлагын чадавхыг бэхжүүлэх сургалтыг яамд, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Засгийн газрын тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлагуудын төлөөллийг хамруулан 2026 оны 06 дугаар сарын 22-23-ны өдрүүдэд зохион байгуулах бэлтгэлийг хангаад байна. Сургалтын арга хэмжээний хүрээнд эрсдэлийн удирдлагыг амжилттай хэрэгжүүлж төлөвшүүлж буй төрийн болон хувийн хэвшлийн 3-5 байгууллагын сайн жишээ, туршлагыг танилцуулах, харилцан судлах, суралцах, түгээн дэлгэрүүлэх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна. 2. Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар болон Эдийн засгийн хөгжлийн яам хамтран 2026 оны 5 дугаар сард "Төрийн бүтээмж – Эдийн засгийн хөгжил" арга хэмжээний хүрээнд "Шилдэг туршлага – Хөгжлийн шийдэл" сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгуулж, яам, агентлаг, төр болон хувийн хэвшлийн байгууллагууд, мөн 21 аймгийн төлөөлөл бүхий нийт 145 оролцогчийг хамруулав. Энэ үеэр Эрдэнэс Монгол нэгдлийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх	80%	80%

							Дотоод аудитын газрын Ерөнхий аудиторыг урьж, нэгдлийн хэмжээнд эрсдэлийн удирдлагын тогтолцоог нэвтрүүлсэн туршлага, эрсдэлд суурилсан хяналтын тогтолцоог хэрэгжүүлж буй сайн туршлага, үр дүнгийн талаар мэдээлэл хийлгэлээ.		
	Гүйцэтгэлийн зорилт 3.2.3 Төрийн байгууллагуудад эрсдэлийн удирдлагын бодлогын баримт бичгийг мөрдүүлэх	Улсын төсөв	Нийт арга хэмжээний хэрэгжилтийн дундаж (хувь)	-	100		Арга хэмжээний хэрэгжилтийн дундаж	90%	
3.2.3.1	Эрсдэлийн удирдлагын бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх сургалтыг үе шаттай зохион байгуулах	Улсын төсөв	Зохион байгуулсан сургалт, арга хэмжээ (тоо)	3	8	-	1.ЗГХХГ-ын албан хаагчдад зориулсан "Эрсдэлийн удирдлагын сургалт", "Эрсдэл хариуцагч албан хаагчдыг чадавхжуулах" сургалтын хөтөлбөрийг боловсруулж, ЗГХХГ-ын даргаар 2026 оны 03-р сарын 09-ний өдөр батлуулсан. Хөтөлбөрийн дагуу ЗГХХГ-ын үйл ажиллагаанд эрсдэлийн удирдлагын тогтолцоог бүрдүүлэн төлөвшүүлэх, эрсдэлийг удирдах үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах, нийт албан хаагчдын эрсдэлийн удирдлагын чадавхыг бэхжүүлэх сургалтыг 2026 оны 03 дугаар сарын 12-16-ны өдрүүдэд зохион байгууллаа. Сургалтад ЗГХХГ-ын албан хаагчдын 89.5 хувь нь хамрагдсан. 2. Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын албан хаагчдад "Төрийн байгууллагын эрсдэлийн удирдлагын тогтолцоо" сэдэвт сургалтыг 2026 оны 03 дугаар сарын 26-ны өдөр зохион байгуулсан. Тус сургалтад ЭМДЕГ-ын төв болон орон нутгийн газар, хэлтсүүдийн дарга, албан хаагчид танхимаар болон цахим хэлбэрээр оролцсон бөгөөд танхимаар 21, цахимаар 67, нийт 88 албан хаагч хамрагдав. 3.Төрийн байгууллагын эрсдэлийн удирдлагын тогтолцоог бэхжүүлэх хүрээнд эрсдэлийн удирдлагын үндэсний сургагч багшийн сургалтыг яамд, Засгийн газрын тохируулагч болон хэрэгжүүлэгч	100%	80%

							агентлагуудын төлөөллийг хамруулан 2026 оны 06 дугаар сарын 24-26, өдрүүдэд зохион байгууллаа. Харин Төрийн албан хаагчийн сургалтыг 2026 оны 06 дугаар сарын 22-23-ны өдрүүдэд зохион байгуулна.		
3.2.3.2	Эрсдэлийн удирдлагын бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх гарын авлагыг тархаах /цахим, хэвлэмэл, сургалт/	Улсын төсөв	Тархаах арга хэмжээ (тоо)	-	1	-	Эрсдэлийн удирдлагын бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх хүрээнд дараах ажлыг гүйцэтгэлээ. Үүнд: - "Эрсдэлийн удирдлага" гарын авлага, хэвлэмэл, 500 ширхэг; - Төрийн байгууллагын эрсдэлийн удирдлагын баримт бичиг, хэвлэмэл, 500 ширхэг; - "Эрсдэлийн удирдлага" гарын авлагын цахим хичээл (10 модуль тус бүрээс 3 постер, нийт 30 ширхэг)-ийг тус тус хэвлүүлээд байна. - Гарын авлагыг цахим ном хэлбэрээр https://ags.gov.mn/blog/2026/06/12/ersdliin-udirdlagiin-guidebook/?preview=true бэлтгэж, улсын хэмжээнд түгээх/тархаах ажлыг гүйцэтгэж байна. Хэвлүүлсэн гарын авлагыг төрийн байгууллагын эрсдэлийн удирдлагын тогтолцоог бэхжүүлэх хүрээнд зохион байгуулах эрсдэлийн удирдлагын Үндэсний сургагч багшийн болон Төрийн албан хаагчийн сургалтаар улсын хэмжээнд тархаахаар төлөвлөөд байна.	80%	80%
Гүйцэтгэлийн зорилт 4.1.4 Эрсдэлийн удирдлагын мэдээллийн сан бий болгох, хөгжүүлэх		Улсын төсөв	Нийт арга хэмжээний хэрэгжилтийн дундаж (хувь)	-	100		Арга хэмжээний хэрэгжилтийн дундаж	85%	
4.1.4.1	Төрийн байгууллагын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, хариу арга хэмжээ авах, хэрэгжилтэд үнэлгээ хийх системийг хөгжүүлэх бэлтгэл ажлыг хангах	Улсын төсөв	Систем хөгжүүлэлт (хувь)	-	30%	-	Төрийн байгууллагуудын эрсдэлийн удирдлагын цахим хяналтын систем хөгжүүлэх ажлын даалгавар, системийн процессын зураглалыг боловсруулаад байна. Цахим хяналтын систем хөгжүүлэхээр сонгогдсон Able компанитай гэрээ байгуулж, Able программд Эрсдэлийн удирдлага цэсийг нэмж үүсгүүлэн, эрсдэлийн удирдлагын	80%	80%

							тогтолцооны бүрэлдэхүүн болох төрийн байгууллагуудын эрсдэлийн бүртгэл, шинжилгээ, хариу арга хэмжээ, төлөвшлийн үнэлгээ, тайлан, төлөвлөгөөг зэргийг нэгтгэх боломжийг бүрдүүлсэн. Уг системийн сайжруулалтын ажил хийж байна.		
4.1.4.2	Засгийн газрын харьяа байгууллагуудын эрсдэлийн удирдлагын үйл явцыг бүртгэх мэдээллийн сан үүсгэх, хөтлөх	Улсын төсөв	Мэдээллийн сангийн хэрэгжилт (хувь)	-	50%	-	Засгийн газрын харьяа байгууллагуудын эрсдэлийг бүртгэх маягтыг 16 яам, 34 агентлаг, 21 аймаг болон нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлж, арга зүйн дэмжлэг үзүүлж, өгөгдөл мэдээллийг цуглуулах суурь бүрдүүлсэн. Түүнчлэн 2023-2026 оны байдлаар ПДИ хийгдсэн болон хяналт, шалгалт хийсэн 6 салбарын зарим байгууллагын 6673 эрсдэл бүртгэгдсэн бөгөөд шинээр боловсруулсан маягтын дагуу мэдээллийг шинэчлэн нэгтгэх ажил хийгдэж байна. Энэ хүрээнд 3 салбарын 3353 эрсдэлийг шинэчилсэн маягтын дагуу цэвэрлэх, сайжруулах ажлыг хийж, мэдээллийн санд нэгтгэж, үр дүнг гаргав. Цуглуулсан мэдээллийг ангилан ялгаж, боловсруулалтын дараа Microsoft Excel программ ашиглан цахим мэдээллийн сан хэлбэрээр бүрдүүлсэн.	85%	80%
4.1.4.3	Засгийн газрын харьяа байгууллагуудын эрсдэлийн удирдлагын цахим хяналтын самбар "Dashboard" боловсруулах	Улсын төсөв	Цахим хяналтын самбар (гүйцэтгэлийг хувиар)	-	1	-	Засгийн газрын харьяа байгууллагуудын эрсдэлийн удирдлагын үйл явцыг бүртгэх, үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах зорилгоор батлагдсан маягтын дагуу цахим хяналтын самбарын загвар, Microsoft Power BI – Асуудлын бүртгэл, Microsoft Power BI – Эрсдэлийн бүртгэл ажиллах горимыг боловсруулж байна.	90%	90%
Гүйцэтгэлийн зорилт 4.3.5 Байгууллагын үйл ажиллагаанд эрсдэлийн удирдлагын тогтолцоог нэвтрүүлэн төлөвшүүлэх		Улсын төсөв	Нийт арга хэмжээний хэрэгжилтийн дундаж (хувь)	-	100		Арга хэмжээний хэрэгжилтийн дундаж	91.3%	

4.3.5.1	Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх журам, эрсдэлийн удирдлагын хорооны дүрэм, хэрэгжүүлэх процессын зураглал боловсруулж батлуулах.	Улсын төсөв	Батлуулсан дүрэм, журам (тоо)	-	2	ЗГХХГ-ын үйл ажиллагаанд эрсдэлийн удирдлагын тогтолцоог бүрдүүлж, төлөвшүүлэх, эрсдэлийг удирдах үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах зорилгоор "Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх журам", "Эрсдэлийн удирдлагын хорооны дүрэм"-ийг боловсруулж, ЗГХХГ-ын даргын 2026 оны А/11 дүгээр тушаалаар батлуулсан. Процессын зураглалаар ЗГХХГ-ын Эрсдэлийн удирдлагын хэрэгжилтийн алхамуудыг тайлбарлаж, тодорхой болгосон. Эрсдэлийн удирдлагын хорооны ээлжит хурлыг 2026 оны 03-р сарын 05-ны өдөр зохион байгуулж, төрийн байгууллагуудын эрсдэлийн удирдлагын хэрэгжилтийн өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал, хэрэгжүүлэх арга хэмжээг хэлэлцэж, үйл ажиллагааны цаашдын чиглэлийг тодорхойлсон.	100%	100%
4.3.5.2	Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын үйл ажиллагаанд тохиолдож болзошгүй эрсдэлийг илрүүлэх шинжилгээ хийж, санал зөвлөмж гаргах.	Улсын төсөв	Эрсдэлийн шинжилгээний тайлан, зөвлөмж (тоо)	-	4	ЗГХХГ-ын Эрсдэлийн удирдлагын хорооны 2026 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн хурлаас гарсан шийдвэрийн дагуу "Байгууллагын албан хаагчдын эрсдэлийн удирдлагын мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх, чиг үүргийг таниулах сургалт"-ыг 2026 оны 03 дугаар сарын 12-16-ны өдрүүдэд зохион байгуулж, сургалтын үеэр албан хаагчдаас цахим холбоосоор болон асуудлын модны аргаар багаар ярилцан тодорхойлсон нийт 90 асуудал, эрсдэлд шинжилгээ хийлээ. Шинжилгээний үр дүнгийн талаар Эрсдэлийн удирдлагын Хорооны хуралд танилцуулж, Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1-ийг хэрэгжүүлэх, албан хаагчдад ээлтэй ажлын байрны бодлого батлуулахаар бодлогын баримт бичгийн төслийг боловсруулаад байна. <i>Нийт бүртгэгдсэн асуудлыг давтамжаар нь эрэмбэлбэл:</i> байгууллагын интернэт сүлжээ	70%	70%

							тасалдсантай холбоотой асуудал 10, ажлын цагийн уян хатан байдал байхгүй болсон асуудал 6, ажиллах орчин нөхцөл хангалтгүй 6, хууль тогтоомжийн нийцэлгүй байдал болон тусгайлсан хууль, дүрэм, журмын зохицуулалт байхгүйтэй холбоотой 16 асуудал тус тус байна. Дээрх шинжилгээний үр дүнд ажлын уян хатан цагийн асуудлыг судлан шийдвэрлэх талаар холбогдох нэгжид санал, зөвлөмжийг өгсөн. ЗГХХГ-ын ажлын байранд асуудал, эрсдэлийг илрүүлэх, бүртгүүлэх цахим холбоосыг нийтийн 32 байршилд болон ажилтнуудын ажлын ширээ, орчинд нийт 130 ширхгийг байршуулж ажилтан, албан хаагч бүр эрсдэл илрүүлэгч байж байгууллагын эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаанд оролцох оролцоог хангасан.		
4.3.5.3	Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын эрсдэлийн удирдлагын мэдээллийн сан үүсгэх, хөтлөх	Улсын төсөв	Мэдээллийн сангийн хэрэгжилт (хувь)	-	100	-	ЗГХХГ-ын Эрсдэлийн удирдлагын тогтолцоо бий болгох зорилгоор байгууллагын албан хаагчид эрсдэл, асуудал бүртгүүлэх боломжийг бүрдүүлсэн "Google form"-д https://forms.gle/LtpoUFifCA4HHL6x9 суурилсан асуулгыг боловсруулж, QR код бүхий бүртгэлийн хуудсыг байршуулсан. Уг хуудсаар асуудал, эрсдэлээ бүртгүүлэх талаарх мэдлэг, ойлголтыг байгууллагын нийт албан хаагчдад сургалтаар олгосон. Бүртгэлийн QR код болон сургалтын явцад нийт 92 асуудал бүртгэгдсэн бөгөөд эдгээрээс 25-ыг нь эрсдэл гэж үзэж, байгууллагын мэдээллийн санд бүртгэсэн.	100%	100%

4.3.5.4	Байгууллагын эрсдэлийн удирдлагын цахим хяналтын "Dashboard" боловсруулах	Улсын төсөв	Цахим хяналтын самбар (тоо)	-	100	-	ЗГХХГ-ын Эрсдэлийн удирдлагын хорооны 2026 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн хуралд байгууллагын удирдлагыг нэгдсэн мэдээллээр хангах байгууллагын эрсдэлийн удирдлагын хэрэгжилтийн үйл явцыг харуулах бүртгэл, мэдээллийн хяналтын цахим самбарын загварын төслийг танилцуулсан. Уг загварын дагуу Power BI-д Microsoft Power BI – Асуудлын бүртгэл, Microsoft Power BI – Эрсдэлийн бүртгэл цахим хяналтын самбарт оруулах мэдээллийн дата (25 эрсдэл)-г оруулж, ажиллах горимыг боловсруулсан.	90%	90%
Гүйцэтгэлийн зорилт 5.1 Төрийн захиргаа, хүний нөөцийн удирдлага, манлайллыг хэрэгжүүлэх		Улсын төсөв	Нийт арга хэмжээний хэрэгжилтийн дундаж хувь	-	100	-	Арга хэмжээний хэрэгжилт	100%	
5.1.1	Газрын болон албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулах, төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнаж, үр дүнг үнэлж дүгнүүлэх	Улсын төсөв	Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт (хувь)	100	100	-	Газрын албан хаагчдын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг, батлуулж, төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган, үр дүнг үнэлж дүгнүүлэн ажиллаж байна.	100%	100%
5.1.2.	Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжид заасан үүргийг хэрэгжүүлэх	Улсын төсөв	Хугацаандаа архивд хүлээлгэн өгсөн эсэх (тийм-1, үгүй-0)	-	1	-	Байгууллагаас баталсан хуваарийн дагуу 2025 оны баримт бичгүүдийг ангилан, ялгаж, архивлан, 20 хадгаламжийн нэгж үүсгэж Тамгын газрын ахлах архивчид хүлээлгэн өгсөн.	100%	100%
			ХАСУМ, ХОМ-тэй холбоотой зөрчил гарсан эсэх (тийм-1, үгүй-0)	-	0	-	(Төрийн албаны тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль Авлигын эсрэг хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон төрийн албан хаагчийн албаны үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн зарчим, манлайллыг удирдлага болгон ажиллаж байна. Хэлтсийн албан хаагчид ХАСХОМ-ыг 2026.02.15-ны өдөр бүрэн гаргаж, ЭБАТ-д баталгааны маягтыг гаргаж өгсөн байна. Одоогоор ХАСУМ, ХОМ-тэй холбоотой		

							зөрчил гарсан тохиолдол илрээгүй байна.		
		-	Шаардлагатай тохиолдолд ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргасан эсэх (тийм-1, үгүй-0)	-	тухай бүр	-	Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас хийгдэж буй Тандалт судалгаа, бусад ажлын хэсэгт ажиллаж буй албан хаагчдын Албаны нууц, байгууллагын нууцыг хадгалахтай холбоотой 10 болон ашиг сонирхолын зөрчилгүй талаарх 3 мэдэгдэл гаргасан.		
5.1.3	Монгол Улсын Тэргүүн Шадар Сайд, байгууллагын удирдлагыг цаг үеийн мэдээ, мэдээллээр хангах, мэргэшлийн болон арга зүйн дэмжлэг үзүүлэх	Улсын төсөв	Гүйцэтгэлийн хувь	-	100	-	<p>Дараах мэдээ, мэдээллийг бэлтгэн боловсруулж, дээд шатны байгууллага болон удирдлагуудад танилцуулан ажилласан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 195 дугаар тогтоолоор баталсан Хяналт шалгалтын объектыг эрсдэлийн ангилалд хамааруулах 13 салбарын шалгуур үзүүлэлтэд шинжилгээ хийж, тайлан боловсруулсан. - Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөөнд ЗГХХГ-аас тусгах саналыг газруудаас авч нэгтгэн боловсруулж, ЗГХХГ-ын даргын 2026 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 01/208 дугаартай албан бичгээр ЭЗХЯ-нд хүргүүлж, тус саналтай холбогдуулан ЭЗХЯ-ны асуудал хариуцсан газрын албан хаагчидтай уулзалт хийж, санал солилцон 9 санал болгон засвар өөрчлөлтийг хийж, удирдлагуудад танилцуулан дахин хүргүүлсэн. - Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оны жилийн хөтөлбөр, арга хэмжээний зарцуулсан төсөв, хүрсэн үр дүнгийн тайланг хэлтсийн хэмжээнд гарган хүргүүлсэн. - ТСБТГ-ын даргын өгсөн үүргээр эрсдэлийн удирдлагын 10 модуль 	100%	100%

						<p>хичээл, ПДИ-ийн аргачлалын агуулгаар танилцуулга бэлтгэсэн.</p> <ul style="list-style-type: none">- ЗГХХГ-аас ЗГХЭГ, Төрийн албаны зөвлөлтэй хамтран хийсэн Төрийн байгууллагын чиг үүргийн шинжилгээ, бүтэц, зохион байгуулалтын оношлогоо" судалгааны тайланг Тэргүүн Шадар сайд, Засгийн газрын гишүүн бөгөөд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга нарт танилцуулж, Засгийн газрын 2026 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн.- ЗГХЭГ-ын удирдлагуудад яамдын чиг үүрэгт хийсэн шинжилгээний үр дүнг танилцуулсан. Шинжилгээний үр дүнг 5 дугаар сарын 13-ны өдрийн Засгийн газрын хуралдаанд танилцуулж, тус хуралдааны 18 дугаар тэмдэглэлээр чиг үүргийн шинжилгээнээс гарсан дүгнэлт, саналд үндэслэн яамд үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж, 2026 оны 05 дугаар сард багтаан Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхийг Засгийн газрын гишүүдэд даалгасан.- Мөн Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын удирдлагад "Засгийн газрын харьяа төрийн болон нутгийн захиргааны байгууллагын нийтлэг чиг үүргийн шинжилгээ" болон "Төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, улсын төсөвт үйлдвэрийн газрын чиг үүрэгт хийсэн шинжилгээ"-ий үр дүнг танилцуулсан.- Төрийн байгууллагуудын 1800-xxxx тусгай дугаарын ашиглалтын өнөөгийн байдалд судалгаа, шинжилгээ хийж тайлан боловсруулан үр дүнг танилцуулсан.- ЗГХЭГ-ын дэд даргад ГБХНХ-ын яаманд 2023 онд хэрэгжүүлсэн ПДИ-ын үр дүнгийн талаар танилцуулга, мэдээлэл боловсруулан 2026 оны 02 дугаар сарын		
--	--	--	--	--	--	---	--	--

						<p>13-нд танилцуулсан. Түүнчлэн 2026 оны 03 дугаар сарын 25-нд ЗГХХГ-ын 2026 онд хэрэгжүүлэх дахин инженерчлэл болон дахин загварчлалын төлөвлөгөө, ЗГХЭГ-аас өгсөн чиглэлийг нэмэлтээр оруулан танилцуулга боловсруулж, удирдлагад хүргүүлсэн.</p> <p>- Төрийн байгуулалтын байнгын хороонд 2026 оны 03 дугаар сарын 11-нд Төрийн байгууллагын бүтээмжийг дээшлүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн ПДИ болон ЭУ-ын танилцуулга, танилцуулгын мэдээллийн агуулга ноте зэргийг боловсруулан нэгжийн удирдлагад хүргүүлсэн.</p> <p>- Нийслэлийн замын хөгжлийн газраас 2026.03.17-ны өдөр ирүүлсэн албан хүсэлтийн дагуу Чиг үүргийн судалгаанд ирүүлсэн тухайн байгууллагын мэдээлэлд дүн шинжилгээ хийж, дүгнэлт, саналын хамт хариу хүргүүлсэн.</p> <p>- Цахим хөгжлийн яамны холбогдох албан хаагчидтай 2026 онд хэрэгжүүлэх ПДИ-д хамтран ажиллах, тус байгууллагын харьяа Төрийн цахим үйлчилгээний газарт цугласан мэдээллийн хүрээнд нэмэлтээр загварчлах үйлчилгээ сонголт хийх, хамтран ажиллах зорилгын хүрээнд Төрийн байгууллагад процессын дахин инженерчлэл хийх нийтлэг аргачлал боловсруулах, аргачлалын дагуу 5 байгууллагад пди-ийн судалгаа шинжилгээ хийх зөвлөх үйлчилгээ /Зөвлөх үйлчилгээ үзүүлэгч хувь хүн/-ний ажлын даалгаварын төслийг боловсруулан хүргүүлж, ажлын агуулгын хүрээнд 2026 оны 02 дугаар сар болон 3 дугаар сард нийт 3 удаагийн уулзалтад холбогдох мэдээлэл, танилцуулга боловсруулан удирдлагад танилцуулсан.</p> <p>-Зөвшөөрлийн тухай хуулийн заалтуудын зөрүүний шинжилгээ ба орон нутгийн засаг даргын олгох</p>	
--	--	--	--	--	--	---	--

							зөвшөөрөл/мэдэгдлийн жагсаалт боловсруулж license.mn зөвшөөрлийн цахим системийн судалгаа гаргахдаа ГТСМТТ өөс license.mn д сайтад байгууллагуудын жагсаалт гаргуулан холбогдох баримт бичгийн бүрдүүлбэрийн шаардлага зөвшөөрлийн хуулийн заалттай нийцүүлсэн судалгаа боловсруулсан. -ЭЗХЯ-ны 5 өдрийн нээлттэй хаалганы хөтөлбөрийг боловсруулж, зохион байгуулж ажилласан.. - Тайлант хугацаанд нэгжийн удирдлага болон байгууллагын удирдлагын гадагш болон дотоод мэдээллийн урсгалтай холбоотой РРТХ болон тайлбар танилцуулгуудыг тухай бүр боловсруулсан.		
5.1.4	Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн хариутай албан бичиг, өргөдөл, гомдлыг шийдвэрлэх, хөтлөгдөж дууссан баримт бичгийг архивлаж, архивд хүлээлгэн өгөх	Улсын төсөв	Албан бичиг, өргөдөл, гомдлын шийдвэрлэлт (хувь)	100	100	-	Тайлант хугацаанд тус газар 331 албан бичиг хүлээн авч хариутай 48 албан бичгийг хугацаанд нь шийдвэрлэсэн байна. Яам, агентлаг, судалгааны байгууллагуудад 180 албан бичиг боловсруулж хүргүүлсэн.	100%	100%
5.1.5	Газрын албан хаагчдын мэдлэг, ур чадварын түвшин, эрэлт хэрэгцээнд үндэслэн холбогдох чиглэлээр сургалт, семинарт хамруулах, мэргэшүүлэх	-	Мэдлэг чадвараа дээшлүүлсэн албан хаагчид (давхардсан тоогоор)	10	11	-	Тайлант хугацаанд дараах цахим болон танхимын сургалт, мэдээллийн үйл ажиллагаанд хамрагдлаа. Үүнд: 1."Хиймэл оюун ухаан ба дижитал шилжилт, Төрийн байгууллага дахь AI хэрэглээ" сэдэвт сургалтад нийт албан хаагч; 2.Удирдлагын академийн Төрийн албаны сургуулийн Эрхэлсэн түшмэлийн багц цагийн сургалтад 2 албан хаагч; 3.Батлан хамгаалах салбарын үйл ажиллагаатай танилцах, цэргийн сургалт бэлтгэлийн анхан шатны мэдлэг олгох сургалтад нийт албан хаагч; 4."Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан	100%	100%

						<p>сэргийлэх” сэдэвт сургалтад нийт албан хаагчид тус тус хамрагдсан.</p> <p>5. Үндэсний бүтээмжийн мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэх оролцогч талуудын төлөөллийг чадавжуулах, хяналт шинжилгээ үнэлгээ хийх, бүтээмжид үзүүлэх нөлөөг үнэлэх ур чадвар олгох сургалтад 1 албан хаагч хамрагдсан.</p> <p>6. БСДШХ-ээс МУИС-ын НУС-ийн Хүн ам зүйн сургалт, судалгааны төвтэй хамтран “Бүс нутгийн хүн ам зүйн өрсөлдөх чадвар”, “Монгол Улсын төрөлтийн шинжилгээ, бодлого” судалгааны тайлангийн хэлэлцүүлгийг зохион байгуулж, ТСБТГ-ын бүх албан хаагчдыг оролцуулсан.</p> <p>7. Тамгын газраас албан хаагчдын идэвхи оролцоог нэмэгдүүлэх, хувь хүний хөгжлийг дэмжих хүрээнд зохион байгуулсан Монгол Банкны Эрдэнэсийн сангийн үзмэр үзэх үйл ажиллагаа,</p> <p>8. ЗГХХГ-аас зохион байгуулсан “Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам”, “Архив, албан хэрэг хөтлөлтийн журам”-ын зөвлөгөө, тайлбар мэдээлэл, “Үндэсний аюулгүй байдал-Төрт ёсны уламжлал” сэдэвт лекц, Төр-Иргэний хяналтын тухай хуулийн хэлэлцүүлэг, Чөлөөлье санаалчилгын хүрээнд хийх мэдээлэл, “Төрийн албан хаагчийн харилцаа, хандлага, ёс зүйн сургалт” болон “Ажлын байрны эмх цэгцийг сайжруулах 5S аргачлал” сэдэвт сургалт.</p> <p>9. ТАЗ-ын “7:4:10” Цахим вебинар мэдээллийн хөтөлбөр</p> <p>10. ЭЗХЯ-наас зохион байгуулсан “Төрийн бүтээмж-Эдийн засгийн өсөлт” 4 өдрийн нээлттэй хаалганы өдөрлөгийн арга хэмжээг зохион байгуулж, оролцсон.</p> <p>11. Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх Эдийн засаг, шинжлэх ухааны салбарын ажилтан, албан хаагч нартай хийх уулзалтад оролцов.</p>	
--	--	--	--	--	--	---	--

5.1.6	Архив, албан хэрэг хөтлөлтий цахим архивын систем нэвтрүүлэх	Улсын төсөв	Цахим архивт нэгтгэсэн баримт бичиг (хувь)	-	100.0	Тайлагнах хугацаа болоогүй байна.	ХБ	ХБ
-------	--	-------------	--	---	-------	-----------------------------------	----	----

Төлөвлөгөөг үнэлсэн:

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЯНАЛТ
ХЭРЭГЖҮҮЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Төсвийн шууд захирагч



П.БАТБААТАР

2026.6.10 (огноо)

Нэгжийн дарга

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн:

ДОТООД ХЯНАЛТ, АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

.....
P. D. J. S

Р.ДЭЖИД

..... (огноо)
2026.06.16

Тайлагнасан:

ТАНДАЛТ СУДАЛГАА, БОДЛОГО
ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН ДАРГА

Нэгжийн дарга

.....
[Signature]

Н.БАЯРМАА

2026.06.15 (огноо)